

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ 11 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 11 дүгээр хуралдааныг 11 цаг 08 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 83.3 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар ирүүлсэн иргэдийн материалыг хэлэлцүүлэх тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Жаргалант сумын багийн Засаг дарга нарын иргэдийг төрийн дээд одон медальд тодорхойлсон материал шаардлага хангахгүй байгаа тул тодорхойлолт болон анкетыг бичихдээ салбартаа гаргасан амжилт бүтээл, шагнуулах үндэслэлийг тодорхой гаргаж, сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар иргэдийн материалыг хэлэлцүүлэн дэмжсэн хурлын тэмдэглэл болон журмын дагуу иргэдийн материалыг бүрэн бүрдүүлэн ирүүлэх;</p> <p>2. Хайрхан багийн иргэн Доржхүүгийн Нямхүү нь авто тээврийн салбарт 45 жил, бариа засал, уламжлалт ухаанаар 17 жил ажилласан зэргийг харгалзаж, аль салбарын гавьяат цол тэмдгээр шагнуулахыг тодорхой болгон журмын дагуу материалыг бүрэн бүрдүүлэн дахин ирүүлэхийг тус тус Жаргалант сумын Засаг дарга Ц.Цогтбаярт үүрэг болгов.</p> <p>3. Мянгад сумын багийн Засаг дарга нар болон албан байгууллагуудаас иргэдийг төрийн дээд одон медальд тодорхойлсон материал шаардлага хангахгүй байгаа тул тодорхойлолт болон анкетыг бичихдээ салбартаа гаргасан амжилт бүтээл, шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар иргэдийн материалыг хэлэлцүүлэн дэмжсэн хурлын тэмдэглэлийн хамт, журмын дагуу иргэдийн материалыг бүрэн бүрдүүлж ирүүлэхийг Мянгад сумын Засаг дарга М.Баатарт үүрэг болгов.</p>
2	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын талаарх танилцуулга	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны эхний хагас жилийн биелэлт, хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хэлэлцэх явцад аймгийн Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> оруулан баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбасүрэн, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.</p>
3	“Аймгийн хошой аварга”, “Аварга	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. “Аймгийн алдарт малчин шалгаруулах журам”-ын</p>

малчин” шалгаруулах журмын төсөл хэлэлцүүлэх тухай	төслийг тусад нь боловсруулж, шалгуур үзүүлэлт, шагнуулах үндэслэлийг нарийвчлалтайгаар гарган, дараагийн хурлаар хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Бямбажавд үүрэг болгов.
---	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР